



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/101/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа

Утас: 7000-3775

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗТХС	Зам тээвэр хөгжлийн сайд



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	Error! Bookmark not defined.



ХӨЛӨНБУЙР СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. Ц.ИДЭРЗОРИГ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ц.Идэрзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 18-нээс 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүн амд нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй чанартай үзүүлэх замаар эрүүл мэндийг сайжруулах, наслалтыг уртасгахад оршино.” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зорилт 1: Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, салбар дундын хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоог сайжруулна.

Зорилт 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3: Хүний нөөцийн бодлогыг эрэлтэд нийцүүлэн тогтвортой хөгжүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа, хандлагыг төлөвшүүлэх үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.

Зорилт 4: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн ил тод байдлыг хангаж, орон нутгийн хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлнэ.

Зорилт 5: Эрүүл мэндийн технологийн дэвшлийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэн байгууллагын хөгжил, ээлтэй байдлыг бүрдүүлнэ.

Зорилт 6: Эм зүйн тусламж үйлчилгээний хүртээмжтэй тогтвортой байдлыг ханган, зайлшгүй шаардлагатай, баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Aхрloger программ хангамж ашигладаг байна.

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.



Аудитын төлөвлөлтийн үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 333,329.2 мянган төгрөгөөс тооцон 6,666.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,666.6 мянган төгрөгөөр тооцсон төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт болох зардлаас мтериаллаг байдлын түвшинг тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53,121.0 мянган төгрөгөөр буюу 13,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,218.4	-	(1,218.4)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	37,605.0	34,751.6	(2,853.4)
Үндсэн хөрөнгө	432,850.4	514,837.8	81,987.4
Хуримтлагдсан элэгдэл	(89,576.9)	(114,371.5)	(24,794.6)
Нийт хөрөнгө	382,096.9	435,217.9	53,121.0
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	382,096.9	435,217.9	53,121.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	382,096.9	435,217.9	53,121.0

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 2,853,4 мянган төрөгийн үнэ төлбөргүй эм, эмнэлгийн хэрэгсэл орлогодсоноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 81,987.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 66,753.2 мянган төгрөгөөр ариун цэврийн байгуулалмж, Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 7,580.0 мянган төгрөгийн машин тоног

төхөөрөмж, 1,395.0 мянган төгрөгийн хашаа, төсвийн урсгал зардлаас 6,259.2 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авсан дүнгээр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 435,217.9 мянган төгрөг болж 53,121.0 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 372,199.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 254,848.4, нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 112,320.0, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 5,031.0 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372,094.4 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байна. Зарцуулаагүй үлдэгдлийн 374.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэл төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Ахмадын болон хүүхдийн сувиллын зардалд 900.0 мянгөн төгрөг, сорьц тээврийн зардалд 35.7 мянган төгрөг олгосон байна. Үүнээс сорьц тээврийн зардалд 35.7 мянган төгрөг, сувиллын эм хоолны зардалд 900.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 42 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 42 эрсдэл тодорхойлж нийт 42 горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 51,295.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 6,123.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 1760,5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 35,447.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж 7,963.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 45,172.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 35,447.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1.Тайлант хугацааны эцэст 1,760.5 мянган төгрөгийн шатахуун /талон / нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 43.5.Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоох

2. Тайлант хугацаанд хийсэн 35,447.8 мянган төгрөгийн худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-

д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч ө баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

3. 2019 онд эмийн тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн бөгөөд 2234,8 мянган төгрөгөөр илүү үнээр эм нийлүүлсэн. нь ТБОНӨБҮХАТухай хуулинд нийцэхгүй бөгөөд үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв .

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Худалдан авах ажиллагаа, гэрээ, гэрээний хэрэгжилт.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 157 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хоцроосон байна. .

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөлөнбуйр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зарцуулалтыг жоолооны тооцооны хуудаснаас явсан зам км, зарцуулсан шатахууныг нормоор зарцуулсан эсэхийг тооцоолж шалгаж үзэхэд 251,6 төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалын дагуу шатахууны зарцуулалтыг батлагдсан норм, нормативаар тооцож, хяналт тавьж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзсэнээс алдаатай байх магадлалтай 40 ажил гүйлгээний журналын бичилтыг шалгахад 25 гүйлгээ буюу 7712,1 мянган төгрөгийн гүйлгээ тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн байна.

2.2. Эрсдэл:

Тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 26.1."Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны зааварыг мөрдөж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	47,984,075.09	62,579,726.06
33	АВЛАГА	00.00	9,600.00
335	Бусад авлага	00.00	9,600.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	9,600.00
35	БАРАА МАТЕРИАЛ	47,984,075.09	62,570,126.06
351	Түүхий эд материал	46,126,125.09	59,395,126.06
35110	Тусгай зориулалттай материал	42,488,866.00	51,913,193.00
35130	Эм боох материал	3,637,259.09	7,481,933.06
354	Хангамжийн материал	1,857,950.00	3,175,000.00
35410	Бичиг хэргийн материал	1,262,830.00	1,549,000.00
35440	Түлш, шатах тослох материал	120.00	550,000.00
35460	Хүнсний материал	595,000.00	1,076,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	547,628,285.49	527,334,505.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	547,628,285.49	527,334,505.62
392	Биет хөрөнгө	547,422,035.53	527,197,005.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	506,188,188.00	506,188,188.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-16,872,939.60	-25,309,409.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,293,041.65	82,293,041.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-38,407,883.98	-49,402,410.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,598,400.00	25,528,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,562,645.79	-12,212,178.97
39214	Бусад үндсэн хөрөнгө	938,000.00	938,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-752,124.75	-826,624.71
393	Биет бус хөрөнгө	206,249.96	137,499.92
39301	Програм хангамж	556,000.00	556,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-349,750.04	-418,500.08
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	595,612,360.58	589,914,231.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	595,612,360.58	589,914,231.68
51	Засгийн газрын хувь оролцоо	595,612,360.58	589,914,231.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		408,972,992.00	408,972,992.00
51101	Өмч: - төрийн	408,972,992.00	408,972,992.00
512	Хуримтлагдсан үр дүн	185,873,681.08	180,175,552.18
51210	Өмнөх үеийн үр дүн	185,873,681.08	185,873,681.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-5,698,128.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	765,687.50	765,687.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	595,612,360.58	589,914,231.68

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	304,179,600.00	372,679,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,668,300.00	5,370,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,668,300.00	5,370,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,668,300.00	5,370,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,668,300.00	5,370,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,511,300.00	367,308,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,191,300.00	254,848,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,191,300.00	254,848,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	210,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	210,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	312,177,851.60	378,377,228.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,177,851.60	378,377,228.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,100,179.60	377,643,163.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,999,281.00	231,106,676.38
210101	Үндсэн цалин	112,106,400.00	163,429,999.65
210102	Нэмэгдэл	41,537,181.00	40,074,246.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,794,000.00	10,836,430.00
210104	Урамшуулал	14,561,700.00	16,766,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,844,200.00	33,621,824.87
210201	Тэтгэврийн даатгал	14,562,800.00	25,663,818.09
210202	Тэтгэмжийн даатгал	1,820,300.00	1,833,615.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,300.00	1,502,433.78
210204	Ажилгүйдлийн даатгал	364,100.00	278,585.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,700.00	4,343,371.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,141,783.00	14,863,132.00
210301	Гэрэл, цахилгаан	2,636,850.00	4,686,562.00
210302	Түлш, халаалт	6,030,078.00	6,760,980.00
210303	Цэвэр, бохир ус	5,474,855.00	3,415,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,779,221.50	22,030,415.34
210401	Бичиг хэрэг	3,253,970.00	3,793,280.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,150,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632,227.50	838,393.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,216,160.00	3,173,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	676,864.00	1,322,630.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	11,752,371.69
2105	Нормативт зардал	47,826,523.09	41,513,833.34
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,027,368.09	17,620,228.34
210502	Хоол, хүнс	22,789,423.00	22,376,485.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,009,732.00	1,517,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,200,144.00	7,496,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	812,000.00	397,000.00
210604	Урсгал засвар	8,388,144.00	7,099,310.00
2107	Томилолт, зочны зардал	1,167,500.00	1,579,800.00
210702	Дотоод албан томилолт	1,167,500.00	1,579,800.00



Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	842,672.00	3,207,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	738,560.00	2,751,280.00
210807	Газрын төлбөр	104,112.00	156,112.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,298,855.01	22,223,779.87
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,298,855.01	22,223,779.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,077,672.00	734,065.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-7,998,251.60	-5,698,128.90
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-7,998,251.60	-5,698,128.90

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	304,179,600.00	372,679,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,668,300.00	5,370,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,668,300.00	5,370,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,668,300.00	5,370,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,668,300.00	5,370,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	299,511,300.00	367,308,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	187,191,300.00	254,848,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	187,191,300.00	254,848,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	210,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	210,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.00	112,249,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	304,179,600.00	370,749,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,179,600.00	370,749,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	298,101,928.00	370,015,034.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,999,281.00	235,612,201.25
210101	Үндсэн цалин	112,106,400.00	167,560,401.52
210102	Нэмэгдэл	41,537,181.00	39,911,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,794,000.00	11,377,099.73
210104	Урамшуулал	14,561,700.00	16,763,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,844,200.00	29,123,400.00
210201	Тэтгэврийн даатгал	14,562,800.00	19,803,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,820,300.00	2,329,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,456,300.00	1,863,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	364,100.00	466,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,640,700.00	4,659,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,141,783.00	14,863,132.00
210301	Гэрэл, цахилгаан	2,636,850.00	4,686,562.00
210302	Түлш, халаалт	6,030,078.00	6,760,980.00
210303	Цэвэр, бохир ус	5,474,855.00	3,415,590.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,463,609.50	10,741,263.65
210401	Бичиг хэрэг	3,201,230.00	4,106,950.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	1,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	632,227.50	838,393.65
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,617,240.00	2,713,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,012,912.00	1,382,100.00
2105	Нормативт зардал	46,593,986.50	52,593,066.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,638,792.50	23,523,161.00
210502	Хоол, хүнс	22,281,543.00	23,009,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,673,651.00	6,060,890.00

/төгрөг/



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,304,896.00	22,127,280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,371,290.00	984,990.00
210602	Тавилга	00.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	5,933,606.00	18,142,290.00
2107	Томилолт, зочны зардал	1,167,500.00	1,579,800.00
210702	Дотоод албан томилолт	1,167,500.00	1,579,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,586,672.00	3,374,892.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,482,560.00	2,918,780.00
210807	Газрын төлбөр	104,112.00	156,112.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	60,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,077,672.00	734,065.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,077,672.00	374,065.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,930,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,930,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,930,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,930,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,930,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,930,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	193,370,086.91	603,108,766.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	193,370,086.91	603,108,766.41
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	17,947,747.38	17,947,747.38
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	185,873,681.08	595,612,360.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,698,128.90	-5,698,128.90
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,972,992.00	765,687.50	180,175,552.18	589,914,231.68

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,199,400.0	372,094,434.9
УРСГАЛ ЗАРДАЛ	372,199,400.0	372,094,434.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,839,400.0	371,734,434.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,686,800.0	235,612,201.3
Үндсэн цалин	167,635,000.0	167,560,401.5
Нэмэгдэл	39,911,200.0	39,911,200.0
Унаа хоолны хөнгөлөлт	11,377,100.0	11,377,099.7
Урамшуулал	16,763,500.0	16,763,500.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,123,400.0	29,123,400.0
Тэтгэврийн даатгал	19,803,900.0	19,803,900.0
Тэтгэмжийн даатгал	2,329,900.0	2,329,900.0
ҮОМШӨ-ний даатгал	1,863,900.0	1,863,900.0
Ажилгүйдлийн даатгал	466,000.0	466,000.0
Эрүүл мэндийн даатгал	4,659,700.0	4,659,700.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,863,900.0	14,863,132.0
Гэрэл, цахилгаан	5,090,400.0	4,686,562.0
Түлш, халаалт	5,277,500.0	6,760,980.0
Цэвэр, бохир ус	4,496,000.0	3,415,590.0
Хангамж, бараа материалын зардал	10,472,400.0	10,469,316.7
Бичиг хэрэг	3,369,100.0	3,896,350.0
Тээвэр, шатахуун	2,284,500.0	1,700,000.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.0	777,046.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариу	2,716,700.0	2,713,820.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,382,100.0	1,382,100.0
Нормативт зардал	52,595,500.0	52,593,066.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,794,900.0	23,523,161.0
Хоол, хүнс	22,736,000.0	23,009,015.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,064,600.0	6,060,890.0
Эд хогшил, урсгал засварын зардал	24,063,200.0	24,057,280.0
Багаж, техник, хэрэгсэл	2,772,000.0	1,674,990.0
Тавилга	3,000,000.0	3,000,000.0
Урсгал засвар	18,291,200.0	19,382,290.0
Томиллолт, зочны зардал	1,584,000.0	1,579,800.0
Дотоод албан томиллолт	1,584,000.0	1,579,800.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,450,200.0	3,436,239.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	240,000.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,984,000.0	2,980,127.0
Газрын төлбөр	156,200.0	156,112.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	60,000.0	60,000.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	360,000.0	360,000.0
Бусад урсгал шилжүүлэг	360,000.0	360,000.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	360,000.0	360,000.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	372,199,400.0	372,094,434.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	254,848,400.0	254,813,634.9
Улсын төсвөөс санхүүжих	254,848,400.0	254,813,634.9



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС		
САНХҮҮЖИХ	112,320,000.0	112,249,800.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	112,320,000.0	112,249,800.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,031,000.0	5,031,000.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,031,000.0	5,031,000.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.0	18.0
Удирдах ажилтан	1.0	1.0
Гүйцэтгэх ажилтан	15.0	15.0
Үйлчлэх ажилтан	2.0	2.0